

**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Нутгийн захиргааны нэгдсэн байр,
Баянголын гудамж 1, 27 дугаар хороо,
Сонгинохайрхан дүүрэг, Улаанбаатар хот, 18082
Утас: (976) 7017 0109
Цахим хуудас: www.shd.mn

2024.12.23 № 03/3424

танай _____-ны № _____-г

Тодруулга авах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, 27 дугаар зүйлийн 27.3 дах хэсэгт заасны дагуу танай байгууллагаас дараах тодруулгыг авах шаардлагатай байна.

“Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил (2-р хороо)” СХДХААА/20240201049 тоот ажлыг 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн үнэлгээний хорооны хурлаар хянан үзээд танай ирүүлсэн төсөвт дараах 5 заалтад арифметик алдаа байж болзошгүй гэж үнэлгээний хороо үзсэн тул батлагдсан төсвийн дагуу хэмжих нэгжийг хүлээн зөвшөөрөх эсэх талаарх хариуг 2024 оны 12 дугаар сарын 25-ний дотор ирүүлнэ үү.

Үүнд:

Явган замын ажлын 07-590-14 үндэслэл бүхий Бетон дэр – 2.25 м3 байх байсныг 2.25 ш гэж хэмжих нэгж зөрүүтэй;

Хайс хашаа хийх ажлын 10-230-07 үндэслэл бүхий Хашлаганд олс татах - 83 м байх байсныг 83 м2 гэж хэмжих нэгж зөрүүтэй;

Сандал хийх ажлын 15-830-04 үндэслэл бүхий WPC модоор суудал хийх – 29.79 м байх байсныг 29.79 м2 гэж хэмжих нэгж зөрүүтэй;

Авирдаг болон олстой тоглоом хийх ажлын 10-230-07 үндэслэл бүхий Хашлаганд олс татах 42.6 м байх байсныг 42.6 м2 гэж хэмжих нэгж зөрүүтэй;

Авирдаг болон олстой тоглоом хийх ажлын 15-830-04 үндэслэл бүхий WPC модоор тавцан хийх 2.75 м байх байсныг 2.75 м2 гэж хэмжих нэгж зөрүүтэй тус тус ирүүлсэн байна.